

БАНКНЫ АШИГТ АЖИЛЛАГААНД НӨЛӨӨЛӨГЧ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ШИНЖИЛГЭЭ

С.Билгүүн /Судалгааны хэлтсийн эдийн засагч/

1. ОРШИЛ

Санхүүгийн систем үр ашигтай ажиллах нь системийн тогтвортой байдлыг хангаж, санхүүгийн зуучлалын цар хүрээг нэмэгдүүлэх болон хөгжлийг дэмжихэд чухал үүрэгтэй байдаг. Иймд манай орны санхүүгийн системийн 97%-ийг бүрдүүлэгч банкны салбарын ашигт ажиллагаанд нөлөөлөгч хүчин зүйлсийг илрүүлж, үр ашгийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх нь салбарын тогтвортой, хэвийн үйл ажиллагаанд эерэг нөлөөг үзүүлэх болно.

Энэхүү судалгааны ажлын зорилго нь банкны системийн ашигт ажиллагааг илэрхийлдэг активын өгөөж (ROA)-д микро (тухайн банкны санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд) болон макро (макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд) түвшний тайлбарлагч хувьсагчид хэрхэн нөлөөлж байгааг тогтоох явдал юм. Түүнчлэн 2011-2014 онуудад бий болох эдийн засгийн үсрэнгүй хөгжил нь банкны салбарын хөгжилд хэрхэн нөлөөлөхийг загварын тусламжтайгаар илрүүлэхийг зорилоо.

Судалгаанд үйл ажиллагаа явуулж буй арилжааны 15 банкны¹ 2004-2010 оны нийт 7 жилийн санхүүгийн тайлан тэнцэл болон орлого зарлагын тайланд үндэслэж, панел тоон өгөгдлийг шинжилгээг ашигласан. Банкны системийн ашигт ажиллагаанд нөлөөлөгч хүчин зүйлсийн талаар судалсан Demirgic-Kunt, Harry Huizinga (1998) нарын боловсруулсан эмпирик загвар, уг эмпирик загварыг өргөтгөх замаар Камбодж, Тайланд, Солонгос, Бангладеш зэрэг улсуудын хувьд судалсан Fadzlan Sufian-ны эмпирик загварт суурилан энэхүү судалгааг гүйцэтгэлээ.

Судалгааны ажлын хоёрдугаар бүлэгт уг банкны ашигт ажиллагаанд нөлөөлөгч хүчин зүйлсийн талаар өмнө нь хийгдсэн голлох судалгааны ажлуудын талаар авч үзсэн. Гуравдугаар бүлэгт судалгаанд ашиглагдсан эмпирик загварын талаар авч үзлээ. Дөрөвдүгээр бүлэгт ашигласан өгөгдөл, хийсэн үнэлгээ, тэдгээрийн үр дүнгийн талаар, тавдугаар бүлэгт дүгнэлт болон санал зөвлөмжийг тусгалаа.

2. СУДЛАГДСАН БАЙДАЛ

Олон улсын хэмжээнд хийгдсэн банкны ашигт ажиллагааг тодорхойлогч хүчин зүйлсийн талаарх судалгаануудад микро (дотоод) болон макро (гадаад) түвшний үзүүлэлтүүдийг авч үзсэн байдаг. Дотоод тодорхойлогч хүчин зүйлс нь банкны санхүүгийн тайлан тэнцэл болон орлого зарлагын тайланд тулгуурлан тодорхойлогддог. Гадаад тодорхойлогч хүчин зүйлс нь банкны хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай шууд холбогддоггүй боловч санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа, гүйцэтгэлд шууд бус замаар нөлөөлдөг эдийн засаг, хууль эрх зүйн орчин зэрэг юм. Судалгааны ажлуудад тухайн судалгааны ажлын үндэслэл, зорилгоос хамаарч олон төрлийн хамаарагч буюу үр ашгийг илэрхийлэгч үзүүлэлтүүдийг сонгон ашиглажээ. Судлаачид ашигт байдлыг илэрхийлэхэд активын өгөөж ба өөрийн хөрөнгийн өгөөж тохиромжтой гэж үздэг байна.

Банкны ашигт ажиллагааны талаар олон улсын хэмжээнд олон тооны судалгаа хийгдсэн байдаг. АНУ-ын банкны системийн ашигт ажиллагаанд нөлөөлөгч хүчин зүйлсийн талаарх эмпирик судалгааг Berger (1995), DeYoung ба Rice (2004), Stiroh ба

¹ Таган буугдсан Анод, Зоос банкуудыг хасав.

Rumble (2006) болон Hirtle ба Stiroh (2007) нар хийжээ. Мөн энэ төрлийн судалгааг Шинэ Зеланд (Ho ба Tripe, 2002), Австрали (Williams, 2003), Грек (Pasiouras ба Kosmidou, 2007; Kosmidou, 2007; Athanasoglou, 2008; Kosmidou болон Zorounidis, 2008) зэрэг баруун Европын өндөр хөгжилтэй орнуудад хийсэн байдаг.

Харин хөгжиж буй улс орнуудын хэмжээнд банкны ашигт ажиллагааны талаарх харьцангуй цөөн судалгаа хийгдсэн байна. Тухайлбал Guru (2002) Малайзын банкны ашигт ажиллагааг тодорхойлогч хүчин зүйлсийг 17 арилжааны банкны 1986-1995 оны 10 жилийн тоон өгөгдөлд тулгуурлан шинжилжээ. Эмпирик судалгааны үр дүнд үр ашигтай зардлын удирдлага нь банкны ашигт байдлыг тодорхойлогч хамгийн чухал нөлөөлөгч хүчин зүйл болох нь харагдсан. Макро түвшний хувьсагчдаас хүүний түвшин өндөр байх нь ашигт байдлыг бууруулдаг, инфляцийн түвшин болон ашигт байдлын хооронд тогтвортой эерэг хамаарал байдгийг тогтоожээ.

Тайландын банкны системийн 1995-2000 оны нийт 5 жилийн тоон өгөгдөл дээр тулгуурлан Chantapong (2005) дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалттай банкуудын ашигт байдлыг харьцуулан шинжилсэн байдаг.

Тунис улсын банкны системийн цэвэр хүүний зөрүү болон ашигт байдалд банкны микро үзүүлэлт, санхүүгийн салбарын бүтэц болон макро эдийн засгийн нөхцөл байдал хэрхэн нөлөөлж байгааг Ben Naceur ба Goaid (2008) нар 1980-2000 оны 10 жилийн тоон өгөгдөлд тулгуурлан тогтоосон. Эмпирик судалгааны үр дүнд өөрийн хөрөнгийн хэмжээ харьцангуй их, үйл ажиллагааны зардал өндөр банкуудын ашигт байдлын хэмжээ өндөр дүнтэй байдгийг тогтоожээ. Харин банкны хэмжээ нь ашигт байдалд сөрөг нөлөөтэй байдаг үр дүн ажиглагдсан. Судалгааг хийж буй хугацаанд хөрөнгийн зах зээлийн хөгжил нь банкны ашигт байдалд эерэг нөлөөг үзүүлсэн байна. Мөн хувийн банкуудын ашигт ажиллагаа төрийн банкуудтай харьцуулахад өндөр байгаа үр дүн илэрсэн. Макро эдийн засгийн нөхцөл байдал банкны ашигт байдалд тогтвортой нөлөөгүй байсан гэж судалгаагаар гарчээ.

Ойрхи Дорнод болон Хойд Африкийн орнуудын 1989-2005 оны арилжааны банкуудын хүүний зөрүү болон ашигт байдалд банкны хууль эрх зүйн орчин, төвлөрөл, санхүүгийн болон институцийн хөгжил хэрхэн нөлөөлж байгааг Ben Naceur ба Omran (2008) нар судалсан байна. Өөрийн хөрөнгийн хүрэлцээ, зээлийн эрсдэл зэрэг банкны үзүүлэлтүүд цэвэр хүүний зөрүү, ашигт байдал, зардлын үр ашигт эерэг нөлөөтэй байдаг нь харагдсан. Тэдний судалгаагаар макро эдийн засаг, санхүүгийн хөгжлийг илэрхийлсэн үзүүлэлтүүд банкны гүйцэтгэлд тогтвортой нөлөөтэй байсан.

Хятад улсын банкны системийн шинэчлэлийн дараах үе буюу 2000-2005 оны хооронд ашигт байдалд нөлөөлөгч хүчин зүйлсийн шинжилгээг Sufian ба Habibullah (2009) нар хийсэн. Судалгааны үр дүнгээр хөрвөх чадвар, зээлийн эрсдэл болон өөрийн хөрөнгийн хүрэлцээ зэрэг үзүүлэлтүүд төрийн өмчит арилжааны банкуудын ашигт байдалд тогтвортой эерэг нөлөөг үзүүлдэг, харин үйл ажиллагааны зардал сөргөөр нөлөөлдөг болохыг тогтоосон. Мөн тэдний судалгаагаар зээлийн эрсдэлийн түвшин өндөр хамтын хөрөнгө оруулалттай (joint stock) арилжааны банкуудын ашигт байдлын түвшин харьцангуй өндөр байх хандлагатай, зардлын өндөр түвшин тэдгээрийн ашигт байдлыг бууруулдаг үр дүн гарсан. Уг судалгааны ажлын үр дүнгээр банкны зах зээлд эзлэх хэмжээ болон зардал нь хотод үйл ажиллагаа явуулж буй арилжааны банкуудын ашигт ажиллагааг бууруулдаг бол хөрөнгийн тараан байршуулалт сайн хийгдсэн, өөрийн хөрөнгийн хүрэлцээ харьцангуй сайн хотын банкууд илүү сайн ашигтай ажиллаж байгаа байгаа нь ажиглагджээ. Эдийн засгийн өсөлт банкуудын ашигт байдалд эерэгээр нөлөөлж байсан бөгөөд харин мөнгөний нийлүүлэлтийн өсөлт

төрийн арилжааны банк болон хотын арилжааны банкуудын ашигт байдлын түвшинд сөрөг нөлөөг үзүүлж байсан үр дүн гарсан байна.

3. ТООН ӨГӨГДӨЛ БОЛОН АРГАЧЛАЛ

Энэхүү судалгаанд банкны дотоод буюу микро түвшний хувьсагчдыг Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа 14 банк болон хадгаламж банктэй нэгдсэн Монгол шуудан банк, нийт 15 арилжааны банкны 2004-2010 онуудын санхүүгийн тайлан тэнцэл болон орлого зардлын жилийн тайланд үндэслэлээ. Макро эдийн засгийн хувьсагчдыг ҮСХ болон МБ-ны сарын бюллетенээс үндэслэж, мэдээллийг бүрдүүлжээ.

3.1. Ашигт байдлыг хэмжих хувьсагч

Олон улсын хэмжээнд хийгдсэн эмпирик судалгааны ажлуудад банкны үр ашиг болон ашигт байдлыг хэмжихдээ цэвэр хүүний зөрүү, активын өгөөж, өөрийн хөрөнгийн өгөөж болон эрсдэлээр жигнэсэн активын өгөөж зэрэг харьцааны үзүүлэлтүүдийг ашигласан байдаг. Энэхүү судалгаанд банкны үр ашиг, ашигт байдлыг хэмжих зорилгоор өмнө нь хийгдсэн эмпирик судалгаануудад түлхүү ашиглагддаг активын өгөөжийг (ROA) хамаарагч хувьсагчаар сонгон авлаа. Активын өгөөж нь тухайн нэг банкны нийт активыг цэвэр ашиг болгох чадамжийг илтгэдэг үзүүлэлт бөгөөд банкны удирдлагын үр ашгийг илтгэх үзүүлэлт болж чаддаг. Түүнчлэн судлаачид ашигт байдлын харьцаанууд нь инфляцитай инвариант шинж чанартай буюу үнийн ерөнхий түвшний өөрчлөлт эдгээр харьцаанд тодорхой нөлөө үзүүлдэггүй учраас үр ашгийг хэмжих хамгийн сайн үзүүлэлт болдог гэж үздэг. Өөрөөр хэлбэл уг үзүүлэлт нь тухайн нэг банкны ашигт байдлыг бусад банк болон нийт банкны системтэй харьцуулахад хамгийн үр дүнтэй хэмжүүр болж чаддаг байна.

Активын өгөөж бага байх нь банк зээлийг зах зээлд болгоомжтойгоор нийлүүлдэг буюу эрсдэлд дургүй хөрөнгө оруулалтын бодлоготой эсвэл их хэмжээний үйл ажиллагааны зардалтай байгааг илтгэдэг. Банкны хугацаатай хадгаламжийн нийт хадгаламжинд эзлэх хувь өндөр байвал хүүний зардал нь салбарын дунджаас харьцангуй өндөр байх магадлалтай. Энэ нөхцөлд банк ашгийн түвшин болон орлогоо нэмэгдүүлэхийн тулд зээлийн тусгай бодлого боловсруулах шаардлагатай тулгардаг.

3.2. Микро буюу дотоод хувьсагчид

Ашигт байдлыг хэмжих эмпирик загварт банкны микро түвшний хувьсагчдаар зах зээлд эзлэх хэмжээг илэрхийлэх нийт активаас натурал логарифм авсан үзүүлэлт (LNTA), чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь (LLP/TL), хүүний бус орлогыг нийт активд харьцуулсан харьцаа (NII/TA), үйл ажиллагааны зардлыг нийт активд харьцуулсан харьцаа (OVC/TA) болон өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт (EQASS) зэрэг харьцааг сонгон авлаа.

Хэмжээ: Загварт активаас натурал логарифм авсан үзүүлэлт болох LNTA-аар тухайн нэг банкны зах зээлд эзлэх хэмжээг илэрхийлсэн бөгөөд хэмжээний үзүүлэлт нь зардлын удирдлагад давуу байдлыг үүсгэж байгаа эсэхийг илрүүлэх зорилготойгоор загварт тусгагдсан болно. Уг хувьсагч нь банкуудын зах зээлд эзлэх хэмжээ нь

зардлын ялгаа болон эрсдэлийн тараан байршуулалтанд нөлөөлж байгаа эсэхийг тогтоох зорилготой юм. Хэрэв хэмжээний үр ашиг эдийн засагт оршин байдаг бол нэг талаас уг хүчин зүйл нь хэмжээ болон үр ашгийн хооронд эерэг хамаарал байгааг харуулна (Akhavain, 1997; Bourke, 1989; Molyneux ба Thornton, 1992; Bikker ба Hu, 2002; Goddard, 2004). Нөгөө талаас хэрэв хөрөнгийг хэт тараан байршуулснаар ашигт байдал буурдаг бол уг хувьсагч сөрөг хамаарлыг харуулна. Өөрөөр хэлбэл хэрэв эдийн засагт хэмжээний үр ашиг оршин байдаг бол LNTA хувьсагч нь эерэг нөлөөтэй байна. Эсрэгээр хөрөнгийн тараан байршуулалт нь эрсдэлийг нэмэгдүүлж байвал уг хувьсагч нь сөрөг нөлөөтэй байх боломжтой юм.

Зээлийн эрсдэл: Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувиар (NPL/TL) зээлийн эрсдэлийг төлөөлүүлж, тэгшитгэлд тайлбарлагч хувьсагчаар орууллаа. Уг хувьсагчийн өмнөх коэффициентийг сөрөг утгатай буюу муу зээл нь банкны ашигт ажиллагааг бууруулдаг гэж таамагласан. Зээлийн эрсдэлийн түвшин өндөр банкуудын зээл эргэн төлөгдөхгүй байх магадлал өндөр байдаг бөгөөд төлөгдөөгүй зээл нь хуримтлагдсаар банкны ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг болохыг Miller ба Noulas (1997) нар тогтоосон байдаг. Мөн уг судалгаагаар чанаргүй зээл буурах нь ихэнх тохиолдолд ашгийн түвшинг нэмэгдүүлдэг болох нь харагдсан. Түүнчлэн Thakor (1987) чанаргүй зээлийн түвшин нь банкны активын чанарыг хэмжих болон ирээдүйн үр дүнг илтгэх гол үзүүлэлт болохыг тэмдэглэсэн байдаг.

Хөрвөх чадварын эрсдэл: Хөрвөх чадварын эрсдэл буюу төлбөр түргэн гүйцэтгэх чадвар (LIQ) нь гэнэтийн их хэмжээний мөнгө харилцах, хугацаагүй хадгаламжаас гарах болон их хэмжээний шинэ зээлийн хүсэлт тавигдах үед банк түүнийг касс дахь мөнгөөрөө хангаж чадах байдлыг илэрхийлдэг. Банкуудын хөрвөх чадвар муутай хөрөнгөөс богино хугацаат хөрөнгө болон касс дахь мөнгө рүү өртөг багатай шилжиж байвал төлбөр түргэн гүйцэтгэх чадвар сайжирч буйг илэрхийлнэ. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг банкны касс дахь мөнгө болон төв банкин дахь харилцахыг нийт активд харьцуулсан харьцаагаар төлөөлүүлэн авч үзлээ.

Хүүний бус орлого: Сүүлийн жилүүдэд санхүүгийн байгууллагуудын шимтгэл хураамж, валютын арилжаа болон дахин үнэлгээний орлого, үнэт цаасны арилжааны орлого зэрэг үндсэн бус үйл ажиллагааны орлогын түвшин мэдэгдэхүйц нэмэгдэж байгаа бөгөөд уг нөлөөг судлах зорилгоор хүүний бус орлогын нийт активт эзлэх хэмжээг (NI/TA) тэгшитгэлд орууллаа. Энэхүү харьцааны үзүүлэлтээр уламжлалт бус (non-traditional) үйл ажиллагааны орлого банкны ашигт байдалд хэрхэн нөлөөлж байгааг хэмжихийг зорисон.

Үйл ажиллагааны зардал: Үйл ажиллагааны зардлыг нийт активт харьцуулсан харьцаагаар (OVC/TA) банкуудын үйл ажиллагааны зардлын ялгааг судлахад ашигладаг. Энэхүү хувьсагч нь банкны бусад зардал буюу аж ахуйн холбогдолтой зарцуулж буй зардлыг илэрхийлэх хувьсагч юм. Өмнө хийгдсэн дийлэнх эмпирик судалгааны үр дүнд үйл ажиллагааны зардал буурах нь банкны ашигт байдлыг нэмэгдүүлдэг гэсэн үр дүн гарсан байдаг. Өөрөөр хэлбэл үйл ажиллагааны зардлыг активт харьцуулсан харьцаа болон ашигт байдлын хооронд сөрөг хамаарал ажиглагддаг. Хэдийгээр ихэнх судалгаагаар дээрх үр дүн гарсан байдаг ч Molyneux ба Thornton (1992) нарын Европын орнуудын хэмжээнд судалсан судалгааны үр дүнд уг хоёр үзүүлэлтийн хооронд тогтвортой эерэг хамаарал ажиглагдсан бөгөөд энэ нь өндөр орлоготой банкууд өндөр бүтээмжтэй хүмүүн капиталд их цалин төлсөнтэй холбоотой гэж тайлбарлажээ.

Өөрийн хөрөнгө: Өөрийн хөрөнгийг нийт активд харьцуулсан харьцааг (EQASS) банкны капиталжуулалт болон ашигт байдлын хоорондын хамаарлыг илрүүлэх зорилгоор тэгшитгэлд орууллаа. Хэдийгээр хөшүүрэг буюу өөрийн хөрөнгийн үзүүлэлт нь банкны ашигт байдлыг тодорхойлогч чухал үзүүлэлт болдог ч уг үзүүлэлт нь ашигт байдалд эерэг болон сөрөг нөлөөний аль алийг нь үзүүлэх боломжтой байдаг. Өөрийн хөрөнгийн харьцаа бага байх нь эрсдэлийн түвшин өндөр байгааг илтгэх бөгөөд EQASS хувьсагчийн өмнөх коэффициент сөрөг тэмдэгтэй байна (Berger, 1995). Гэхдээ уг харьцаа өндөр байх нь эх үүсвэрийн зардлыг бууруулах бөгөөд банкны ашигт байдалд эерэг нөлөөг үзүүлэх боломжтой байдаг (Molyneux, 1993).

3.3. Макро буюу гадаад хувьсагчид

Банкны ашигт байдал нь макро эдийн засгийн нөхцлөөс өндөр хамаардаг байна. Эдийн засгийн өсөлт өндөр байх нь банкууд их хэмжээний зээлийг зах зээлд нийлүүлж, улмаар хүүний орлогоо нэмэгдүүлэх боломжийг олгодог бөгөөд активын чанарыг дээшлүүлдэг байна. Neely ба Wheelock (1997) судалгаандаа нэг хүнд ноогдох орлогын хэмжээг хэрэглэсэн бөгөөд уг хувьсагч нь банкны ашигт ажиллагаатай хүчтэй эерэг хамааралтай байгааг тогтоосон. Dermigic-Kunt ба Huizinga (2001), Bikker ба Hu (20002) нар бизнесийн мөчлөг болон ашигт ажиллагааны хооронд тогтвортой хамаарал байгааг олж тогтоожээ.

Банкны ашигт ажиллагаа болон эдийн засгийн өсөлт хоорондын хамаарлыг хэмжихийн тулд бодит ДНБ-ээс логарифм авсан үзүүлэлт (LNGDP), бодит ДНБ-ийн өсөлт (RGDP_GRO), инфляцийн түвшин (INF), төвлөрлийн харьцаа буюу 3 том банкны нийт банкны системд эзлэх активын хувь хэмжээ (CR3), тухайн зах зээлийн өрсөлдөөний хэлбэрийг тодорхойлогч Herfindah-Hirschman индекс болон хямралын дамми DUM(2008-2009) зэрэг үзүүлэлтүүдийг ашиглаллаа.

Дотоодын нийт бүтээгдэхүүн: ДНБ нь макро эдийн засгийн үзүүлэлт дотроос нийт эдийн засгийн үйл ажиллагааг хэмждэг хамгийн нийтлэг бөгөөд тохиромжтой үзүүлэлт юм. Эдийн засгийн байдал хүндэрч, уналтанд орсон үед банкны системийн чанаргүй зээлийн хэмжээ өсч, улмаар банкны тогтвортой үйл ажиллагаанд сөрөг нөлөөг үзүүлдэг. Иймд эдийн засгийн орчин тогтвортой байх нь санхүүгийн зуучлал гүнзгийрэх таатай нөхцлийг бүрдүүлж, бүтээмжтэй бөгөөд эрсдэл багатай хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх боломж нэмэгддэг. Энэ нөхцөлд банкуудын болзошгүй эрсдэлийн сан болон бусад чанаргүй зээлтэй холбоотой гарах зардлууд буурах тул ашигт ажиллагаа нэмэгдэх боломжтой байдаг. Уг холбоог манай орны хувьд ямар байгааг тогтоох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагааг бодит ДНБ-ээс логарифм авсан үзүүлэлт (LNGDP), бодит ДНБ-ий өсөлт (RGDP_GRO) зэрэг үзүүлэлтээр төлөөлдүүлэн авч үзлээ.

Инфляци: Инфляци нь ажиллах хүчний зардлыг нэмэгдүүлэх шууд нөлөөтэй байдгаас гадна тухайн банкны нэрлэсэн хүүний түвшин болон активын үнэлгээнд дам нөлөө үзүүлдэг гэж Staikouras ба Wood (2003) үзсэн байдаг. Банкны ашигт ажиллагаанд инфляцийн түвшин нөлөөлөх эсэх нь түүнийг таамаглах боломжтой эсэхээс хамаардаг гэж Perry (2002) үзсэн байдаг. Хэрэв инфляцийг урьдчилан таамаглаж чаддаг бол нэрлэсэн хүүний түвшинг нэмэгдүүлэх замаар хүүний зөрүүг багасгаж, ашгаа өсгөх боломжтой байдаг. Харин инфляцийг таамаглах боломжгүй нөхцөлд нэрлэсэн хүүний түвшинг хугацааны хоцрогдолтойгоор өөрчилж, улмаар

банкны зээлийн хүүний зардал нэмэгдсэнээр ашигт ажиллагаанд сөрөг нөлөөг үзүүлдэг байна.

Төвлөрлийн харьцаа: Эмпирик судалгаануудад ашигладаг зах зээлийн бүтцийг илэрхийлдэг төвлөрлийн харьцааг (CR3) ашигт ажиллагаанд хэрхэн нөлөөлж байгааг тогтоох зорилгоор судалгаандаа орууллаа. Төвлөрлийн харьцаанд зах зээлд активын хэмжээгээр тэргүүлэх байр суурьтай 3 банкны активын нийт банкны системд эзлэх хэмжээг авч үзлээ.

Өрсөлдөөний зэрэг: Энэхүү хувьсагч нь зах зээлийн төвлөрөл болон өрсөлдөөний зэргийг тодорхойлдог судалгаануудад өргөн ашиглагддаг индекс юм. Энэхүү индекс нь банкуудын зах зээлд эзлэх хэмжээний квадрат нийлбэрээр тодорхойлогддог. Хэрэв зах зээлд n ширхэг банк байдаг гэж үзвэл индекс (НИ) нь $1/n$ -ээс 1 хооронд утгаа авах болно.

Хямралын дамми: Дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал нь банкуудын ашигт ажиллагаанд хэрхэн нөлөө үзүүлснийг илрүүлэх зорилгоор хямралын дамми (DUM2009-2010)-г судалгаандаа орууллаа. Уг дамми хувьсагчийн өмнөх тэмдэг сөрөг байхаар хүлээгдэж байна.

Хүснэгт 1-д ашигт байдлыг тодорхойлогч хувьсагчдын тэмдэглэгээ, коэффициентийн хүлээгдэж буй тэмдгийг өмнө нь олон улсад хийгдэж байсан судалгааны ажлуудад үндэслэн тодорхойллоо.

Хүснэгт 1. Загварт ашиглагдаж байгаа хувьсагчдын тодорхойлолт

| Хувьсагч | Тодорхойлолт | Таамаглаж буй тэмдэг |
|---------------------------|---|----------------------|
| Хамаарагч хувьсагч ROA | t -р жилийн j -р банкны активын өгөөжийн түвшин | |
| Үл хамаарагч хувьсагч | Дотоод нөлөөлөгч хүчин зүйлс | |
| LNTA | Хэмжээг илэрхийлсэн үзүүлэлт: j -р банкны t -р жилийн нийт активаас натурал логарифм авсан Зээлийн эрсдэл: Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хэмжээ бөгөөд j -р банкны t -р жилд чанаргүй зээл нийт зээлийн хэдэн хувийг бүрдүүлж байгааг илэрхийлсэн үзүүлэлт | +/- |
| LLP/TL | Хөрвөх чадварын үзүүлэлт: j -р банкны t -р жилийн касс дахь мөнгө, төв банкин дахь харилцахыг нийт активт харьцуулсан харьцаа. Харьцаа өндөр байх нь хөрвөх чадварын өндөртэй байгааг харуулна | - |
| LIQ/TA | Активын бүтэц: Хөрөнгийн тараан байршуулалт буюу бүтцийг илэрхийлэх үзүүлэлт бөгөөд j -р банкны t -р жилийн хүүний бус орлогыг нийт активт харьцуулсан харьцаа | +/- |
| NI/TA | Зардлын удирдлага: j -р банкны t -р жилийн үйл ажиллагааны зардлыг нийт активт харьцуулсан харьцаа бөгөөд зардлын үр ашгийг илэрхийлнэ. Уг харьцаа өндөр байх нь зардлын үр ашиг бага байгааг илтгэнэ | + |
| OVC/TA | Эрсдэлээс зайлсхийх зэрэглэл: j -р банкны t -р жилийн өөрийн хөрөнгийг нийт активт харьцуулсан харьцаа бөгөөд банкны капиталын чадамжийг илэрхийлэх үзүүлэлт. Харьцаа бага байх нь хөшүүрэг бага байгааг илтгэх боловч тэр хэмжээгээр эрсдэлийн түвшин бага байна | - |
| EQASS | Гадаад хувьсагчид | +/- |
| LNGPD | t -р жилийн ДНБ натурал логарифм авсан үзүүлэлт | +/- |
| RGDP_GROWTH | Тухайн оны бодит ДНБ-ий өсөлтийн хувь. | + |

| | | |
|----------------|--|-----|
| INFL | Жилийн инфляцийн түвшин | +/- |
| CR3 | Гурван том банкны активын нийт банкны системийн активд эзлэх дүн | +/- |
| HHI | | +/- |
| DUM(2009-2010) | 2009-2010 онуудыг хямралын жил гэж авч үзэв | - |

Хүснэгт 2-д тэгшитгэлд ашиглагдах тайлбарлагч хувьсагчдын статистик үзүүлэлтүүдийг харууллаа.

Хүснэгт 2. Үл хамаарагч хувьсагчдын хураангуй статистик

| Хувьсагчид | Дундаж утга | Хамгийн их утга | Хамгийн бага утга | Стандарт хазайлт |
|-------------|-------------|-----------------|-------------------|------------------|
| ROA | 0.00 | 0.06 | -0.30 | 0.10 |
| LNTA | 18.29 | 1.48 | 15.66 | 21.18 |
| LOANS/TA | 0.61 | 0.13 | 0.28 | 0.85 |
| LLP/TL | 0.12 | 0.17 | 0.01 | 1.00 |
| NII/TA | 0.06 | 0.11 | 0.00 | 0.60 |
| OVC/TA | 0.08 | 0.10 | 0.00 | 0.71 |
| EQASS | 0.24 | 0.23 | 0.05 | 0.91 |
| LNGPD | 15.07 | 0.13 | 14.86 | 15.24 |
| RGDP_GROWTH | 0.07 | 0.04 | -0.01 | 0.11 |
| INFL | 0.11 | 0.06 | 0.02 | 0.21 |
| CR3 | 0.56 | 0.07 | 0.48 | 0.68 |
| HHI | 0.13 | 0.17 | 0.12 | 0.02 |

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

3.4. Эконометрик загвар

Банкны ашигт байдал нь банкны дотоод, гадаад хүчин зүйлсээс хэрхэн хамаарч байгааг тогтоохын тулд дараах шугаман регрессийн загварыг үнэлнэ:

$$y_{it} = \delta_t + \alpha'_{jt}X_{jt} + \beta'_{it}Y_{jt} + \varepsilon_{jt} \quad (1)$$

Үүнд j гэдэг нь тухайн банкыг илэрхийлэх индекс, t нь тухайн жилийг илэрхийлэх хугацааны индекс, y_{it} нь j -р банкны t -р жилийн активын өгөөжийг (ROA) илэрхийлнэ. X нь банкны дотоод тайлбарлагч хувьсагчдыг илтгэх бөгөөд харин Y нь гадаад буюу макро эдийн засгийн хувьсагчдыг илэрхийлэх үзүүлэлт болно. Тэгшитгэл (1)-ийг панел тоон өгөгдлийн Тогтмол нөлөөлөл (Fixed effect) болон санамсаргүй нөлөөлөл (Random effect)-ийн загварыг ашиглаж хамгийн бага квадратын аргаар үнэлсэн. Тогтмол болон санамсаргүй нөлөөллийн загваруудыг сонгохдоо Хаусмэнийн тестийг ашигласан болно.

Тэгшитгэл (1)-ийн матрицуудыг хүснэгт 1-д тодорхойлогдсон хувьсагчдаар дэлгэрэнгүй тэгшитгэл хэлбэрээр илэрхийлвэл:

$$ROA_{jt} = \delta_0 + \alpha_1 LNTA_{jt} + \alpha_2 LOANS/TA_{jt} + \alpha_3 LLP/TL_{jt} + \alpha_4 NII/TA_{jt} + \alpha_5 OVC/TA_{jt} + \alpha_6 EQASS_{jt} + \beta_1 LNGPD_t + \beta_2 RGDP_{GROWTH_t} + \beta_3 INFL_t + \beta_4 CR3_t + \beta_5 DUMCRIS + \varepsilon_{jt}$$

Үүнд үлдэгдэл нь $\varepsilon_{jt} = \gamma_{jt} + u_{jt}$ хэлбэртэй байх бөгөөд γ_{jt} нь тухайн нэг банкны үл мэдэгдэх онцгой нөлөөллийг илэрхийлэх үзүүлэлт, u_{jt} нь идиосинкратик алдаа буюу $u_{jt} \sim N(0, \sigma^2)$ гэсэн хэвийн тархалттай хамааралгүй санамсаргүй хэмжигдэхүүнүүд байна.

Олон хүчин зүйлсийн тэгшитгэлийн тайлбарлагч хувьсагчдын хоорондын шугаман хаамарлыг Спирмэний корреляцийн коэффициентоор тооцон хүснэгт 3-д харууллаа. Kennedy (2008) -ийн судалгааны үр дүнгээр тайлбарлагч хоёр хувьсагчийн хоорондын корреляцийн коэффициент 0.70-оос дээш буюу мэдэгдэхүйц хүчтэй хамааралтай бол мультиколлинеаритийн асуудал үүсдэг гэдгийг тогтоосон байна. Хүснэгт 3-аас харахад банкны микро хувьсагч өөрийн хөрөнгийн нийт активт эзлэх хэмжээ (EQASS) болон активаас натурал логарифм авсан үзүүлэлтийн (LNTA) хоорондын шугаман хамаарал сөрөг 0.72 байгаа нь үнэлгээ гажуудалтай гарах асуудлыг үүсгэж болзошгүй байна. Мөн төвлөрлийг илэрхийлэх CR3, ННН болон бодит ДНБ-ээс натурал логарифм авсан үзүүлэлтийн хооронд дээрх асуудал тулгарч байна. Бусад үзүүлэлтийн хувьд мультиколлинеарийн асуудал үүсээгүй байна.

Хүснэгт 3. Тайлбарлагч хувьсагчдийн Спирмэний корреляцийн коэффициент

| | LNTA | LIQ/TA | NPL/TL | NI/TA | OVC/TA | EQASS | LNGPD | GDP_GR | INFL | CR3 | ННН |
|--------|--------------|--------|--------|-------|--------|-------|-------------|--------|------|------------|-----|
| LNTA | 1.00 | | | | | | | | | | |
| LIQ/TA | 0.00 | 1.00 | | | | | | | | | |
| NPL/TL | -0.31 | -0.10 | 1.00 | | | | | | | | |
| NI/TA | -0.02 | -0.09 | 0.34 | 1.00 | | | | | | | |
| OVC/TA | -0.42 | 0.03 | 0.31 | 0.42 | 1.00 | | | | | | |
| EQASS | -0.72 | -0.15 | 0.32 | 0.06 | 0.31 | 1.00 | | | | | |
| LNGPD | 0.29 | -0.07 | 0.08 | 0.26 | -0.17 | -0.07 | 1.00 | | | | |
| RGDP_G | | | | | | | | | | | |
| RO | -0.16 | -0.07 | -0.19 | -0.19 | 0.12 | 0.06 | -0.48 | 1.00 | | | |
| INFL | 0.05 | -0.10 | -0.16 | 0.04 | -0.05 | -0.02 | 0.35 | 0.56 | 1.00 | | |
| CR3 | 0.27 | 0.00 | 0.13 | 0.30 | -0.17 | -0.10 | 0.92 | -0.67 | 0.15 | 1.0 | |
| ННН | 0.29 | 0.02 | 0.13 | 0.28 | -0.18 | -0.08 | 0.96 | -0.63 | 0.11 | 0.9 | 1.0 |

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

4. ЭМПИРИК ЗАГВАРЫН ҮНЭЛГЭЭ

Банкны ашигт ажиллагааг тодорхойлогч хүчин зүйлсийн загварыг үнэлэхдээ банкны салбарт үйл ажиллагаа эрхэлж буй 15 арилжааны банкны 2004-2010 онуудын жилийн санхүүгийн тайлан тэнцэл, орлого зардлын тайлангийн тоон өгөгдөлд үндэслэн үнэлгээг панел тоон өгөгдлийн шинжилгээний тогтмол болон санамсаргүй нөлөөллийн аргаар тооцоо /Дэлгэрэнгүй үнэлгээг Хавсралт 1-ээс харна уу/. Загварын эконометрик үнэлгээг тооцоходоо Stata 11.0 программыг ашигласан болно.

Үнэлгээний үр дүнг тэгшитгэл хэлбэрээр илэрхийлвэл:

$$ROA_{jt} = -0.27 \cdot NPL/TL_{jt} + 0.26 \cdot NI/TA_{jt} - 0.32 \cdot OVC/TA_{jt} + 0.10 \cdot EQASS_{jt} + 0.43 \cdot GDP_GRO + \varepsilon_{jt} \quad (3)$$

t stat: (-7.7) (3.87) (-4.2) (3.59) (2.8) **R²=0.58**

Эмпирик загварын детерминацын коэффициент буюу тайлбарлах чадварын үзүүлэлт 0.58 гэж гарсан нь банкны системийн ашигт ажиллагааг илэрхийлэгч үзүүлэлт болох активын өгөөжийн 58%-ийг хөрвөх чадварын үзүүлэлт, чанаргүй зээлийн хэмжээ, хүүний бус орлого, үйл ажиллагааны зардал, өөрийн хөрөнгийн хүрэлцээ болон бодит ДНБ-ий өсөлт зэрэг үзүүлэлтээр тайлбарлаж байна.

4.1. Микро хувьсагчдын нөлөөлөл

Тухайн нэг банкны зах зээлд эзлэх хэмжээ LN(TA) болон ашигт ажиллагааны хооронд сонгож авсан загварын хувьд тогтвортой хамаарал ажиглагдсангүй. Эндээс дүгнэхэд манай орны банкны системд өргөжилтийн үр өгөөж төдийлөн ажиглагдахгүй байгаа бөгөөд банк зах зээлд эзлэх хэмжээгээ нэг нэгжээр нэмэгдүүлэхийн тулд гаргаж буй зардал нь орж ирэх орлогоос өндөр байгааг илтгэж байна.

Загварын үр дүнгээс чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хэмжээ (NPL/TL) нь банкны системийн активын өгөөжид сөргөөр нөлөөлдөг гэсэн үр дүн статистикийн 1%-ийн ач холбогдолтойгоор илэрсэн бөгөөд ашигт ажиллагаа болон зээлийн нийт дүнд эзлэх чанаргүй зээлийн хэмжээний хооронд сөрөг хамаарал оршиж байдаг нь ажиглагдлаа. Энэхүү үр дүн нь зээлийн эрсдэлийн түвшин өндөр банкуудын ашигт ажиллагаа бусад банкуудтай харьцуулахад харьцангуй бага байдгийг илтгэнэ. Энэ нь бусад улсын хэмжээнд хийгдсэн эмпирик судалгааны үр дүнтэй нийцтэй гарлаа.

Хүүний бус орлогын нийт активд эзлэх хэмжээ нь (NI/TA) ашигт ажиллагаатай эерэг хамааралтай байдаг нь судалгааны үр дүнгээс харагдлаа. Энэ нь хүүний бус орлогоороо ашгаа олдог банкуудын ашигт ажиллагаа харьцангуй өндөр байгааг илтгэнэ. Энэхүү эмпирик судалгааны үр дүн нь шинэ төрлийн бизнесээс олж буй орлого нь банкны ашигт ажиллагааг тогтвортой дэмждэг гэсэн Canals (1993)-ийн судалгааны үр дүнтэй нийцтэй байна. Тэрээр шинэ төрлийн бизнесээс олж буй орлого нь банкны ашигт байдлыг тогтвортойгоор дэмждэг гэсэн дүгнэлтийг гаргасан байдаг. Гэвч Stiroh (2004)-ийн АНУ-ын банкны системд хийсэн судалгаагаар хүүний бус орлогод түшиглэн ашигт ажиллагаагаа нэмэгдүүлэх боломжтой хэдий ч ийм төрлийн ялангуяа валют, үнэт цаасны арилжааны орлогын эх үүсвэр нь эрсдэл өндөртэй гэдгийг судалгаагаараа харуулсан байдаг.

Үйл ажиллагааны зардлын нийт активд эзлэх хэмжээ (OVC/TA) болон ашигт байдлын хооронд тогтвортой сөрөг хамаарал ажиглагдлаа. Банкуудын үйл ажиллагааны зардлын нийт активд эзлэх хэмжээ 1%-иар буурахад активын өгөөжийг 0.35%-иар нэмэгдүүлэх боломжтой юм. Уг судалгааны үр дүн Pasiouras ба Kosmidou (2007), Kosmidou (2008)-ын Грек улсын хувьд хийгдсэн, мөн өмнө нь бусад улс орнуудын хувьд судалсан олон судлаачдын эмпирик судалгааны үр дүнтэй нийцтэй гарлаа. Өнөөдрийн байдлаар банкууд үйл ажиллагааны зардлаа бууруулснаар ашигт ажиллагаагаа нэмэгдүүлэх боломжтой нь судалгаагаар харагдлаа.

Өөрийн хөрөнгийг хүрэлцээ (EQASS) болон үр ашгийг илэрхийлэгч активын өгөөжийн хооронд тогтвортой эерэг хамаарал санамсаргүй нөлөөллийн аргачлалаар үнэлсэн тэгшитгэлийн үр дүнгээс гарлаа. Уг үр дүн нь өмнө хийгдсэн Berger (1995), Dermiguc-Kunt ба Huizinga (1999), Staikouras ба Wood (2003), Goddard (2004), Pasiouras ба Kosmidou (2007) болон Kosmidou (2008) зэрэг судлаачдын эмпирик судалгааны үр дүнтэй нийцтэй байна.

4.2. Макро хувьсагчдын нөлөөлөл

Эдийн засгийн өсөлтийг илэрхийлсэн бодит ДНБ-ий өсөлт (RGDP_GRO) болон банкны ашигт ажиллагааны хооронд тогтвортой эерэг хамаарал оршдог байна. Эдийн засгийн таатай, тогтвортой өсөлт нь мөнгөний эргэлтийг хурдасгаж, зээлийн эргэн төлөлт, банкуудын зээлийн өсөлт зэрэгт эерэг нөлөөг үзүүлэх бөгөөд энэ нь эргээд

банкны ашигт ажиллагааг нэмэгдүүлэх боломжтой юм. Эдийн засаг 1%-иар өсөх нь банкны ашигт ажиллагааг 0.43%-иар нэмэгдүүлнэ.

Загварт сонгон оруулсан бусад макро эдийн засгийн үзүүлэлт болон банкны ашигт ажиллагааны үзүүлэлтийн хооронд тогтвортой хамаарал ажиглагдсангүй.

4.3. Эдийн засгийн өсөлтийн ашигт байдалд нөлөөлөх хандлага

Монгол Улсын эдийн засгийн 2011-2015 онуудын таамаглаж буй өсөлт дунджаар 13.5%-тай байхаар байна. Энэ нь Засгийн газраас уул уурхайн томоохон төслүүдийг хэрэгжүүлж, эдийн засгийн эргэлтэнд оруулах шийдвэрийг гаргасан, дэд бүтцийн салбарт томоохон бүтээн байгуулалтуудыг хийхээр шийдвэрлэсэн болон хөрш орнуудын эдийн засаг хурдацтай хөгжихөөр хүлээгдэж байгаа зэргээс шалтгаална. Иймд ойрын ирээдүйн эдийн засгийн энэхүү өсөлт нь банкны системийн ашигт ажиллагаанд хэрхэн нөлөөлөхийг загварын тусламжтайгаар тогтоохыг зорилоо /Хүснэгт 4/.

Хүснэгт 4. Монгол улсын эдийн засгийн өсөлтийн таамаглал

| | Бодит ДНБ-ий өсөлт /хувь/ | | | | | |
|------------------------------------|---------------------------|------------|------------|-------------|-------------|-------------|
| | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 |
| Олон Усын Валютын сан | 6.1 | 10.3 | 7.6 | 22.9 | 15.7 | 9 |
| Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо | 6.1 | 8.2 | 7.8 | 20.6 | n/a | n/a |
| Дэлхийн Банк | 6.1 | 7 | 6.2 | 27.7 | 18.5 | 12.9 |
| Дундаж төсөөлөл | 6.1 | 8.5 | 7.2 | 23.7 | 17.1 | 11.0 |
| Активын өгөөж | 1.1 | 3.7 | 3.1 | 10.2 | 7.4 | 4.7 |


Эх сурвалж: IMF article IV; Эдийн засгийн өсөлт, бодит салбарын хөгжлийн хандлага; <http://www.econstats.com/weo/CMNG.htm>

Энэхүү эдийн засгийн хүлээгдэж буй өндөр өсөлт нь эргээд банк, санхүүгийн салбарын ашигт ажиллагаа, тогтвортой байдалд дэмжлэг үзүүлэхээр байна. **Бусад хүчин зүйлс тогтмол** нөхцөлд эдийн засгийн эрчимтэй өсөлтөөс шалтгаалж банкны системийн активын өгөөж 2011-2015 онуудад дунджаар 5.0%-д байх төлөвтэй байна.

4.4. Ашигт ажиллагааны хүчин зүйлсээрх задаргаа

Банкуудын ашигт ажиллагаанд эдийн засгийн өсөлт 2004-2008 онуудын хооронд голлох нөлөөлөгч хүчин зүйл нь болж иржээ. 2004-2008 онуудад бодит ДНБ-ий тогтмол өсч байсан нь банкны салбарын ашигт ажиллагаанд дунджаар 3.9%-ийн эерэг нөлөөг үзүүлж иржээ. Дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын нөлөө манай орны бодит эдийн засгийн өсөлтийг сааруулж, 2009 онд эдийн засаг 1.6%-иар буурахад хүргэсэн. Энэхүү эдийн засгийн бууралт нь 2009 онд банкны салбарын активын өгөөжийг -0.5%-иар буурахад нөлөөлсөн /Зураг 1/.

Зураг 1. Тайлбарлагч хувьсагчдын ашигт ажиллагаанд нөлөөлдөг хэмжээ /баруун тэнхлэг ROA/



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Банкуудын үйл ажиллагааны зардлын ашигт ажиллагаанд нөлөөлөгч хэмжээ 2004-2007 онуудад харьцангуй тогтвортой буюу дунджаар -2%-тай байжээ. Эдийн засагт хэт халалтын шинж тэмдгүүд илэрч байсан 2008 онд банкуудын үйл ажиллагааны зардал нэмэгдэж, банкны системийн активын өгөөжид уг үзүүлэлт 3.2%-ийн сөрөг нөлөөг үзүүлсэн бол 2009 онд уг дүн эрс нэмэгдэж -5.6%-д хүрсэн.

Банкны системийн чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх дүн 2004-2007 онуудад тогтвортой буурч, дунджаар 6.5%-тай байсан. Зээлийн эрсдэл харьцангуй бага байсан тухайн хугацаанд чанаргүй зээлийн дүн активын өгөөжийг дунджаар -2.3%-иар бууруулдаг байжээ. Гэвч эдийн засгийн өсөлт саарч, 2009 онд бодит ДНБ-ий өсөлт -1.6%-д хүрсэн нь бизнес эрхлэгчдийн борлуулалтын эргэц удаашрахад нөлөөлж, улмаар зээлдэгчдийн төлбөрийн чадварыг муутгаж, зээлийн эрсдэлийг нэмэгдүүлсэн. Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх дүн 2009, 2010 онуудад харгалзан 17.4%, 11.5%-д хүрсэн нь банкны системийн активын өгөөжийг -6.2%, -5.7%-иар бууруулахад нөлөөлжээ. Чанаргүй зээлийн нийт дүн хямралын жилүүдэд ийнхүү нэмэгдсэн нь активын өгөөж мөн хугацаанд сөрөг дүнтэй гарахад хамгийн гол нөлөөг үзүүлж байжээ.

2004-2007 онуудад хүүний бус орлого буюу хураамж, шимтгэл валютын балансын дахин үнэлгээний болон арилжааны орлого нь активын өгөөжид дунджаар 0.7%-ийн эерэг нөлөөг үзүүлдэг байжээ. Гэвч 2008-2009 онуудад хүүний бус орлогын ашигт ажиллагаанд нөлөөлөх нөлөөлөл мэдэгдэхүйц нэмэгдэж дунджаар 2.7%-иар активын өгөөжийг нэмэгдүүлсэн байна. Хүүний бус орлогын нөлөөлөл ийнхүү нэмэгдэхэд төгрөгийн валюттай харьцах ханш 2009 онд огцом суларснаас гадаад валютын эх үүсвэр өндөр буюу валютын урт позицтой зарим банкууд балансын дахин үнэлгээний ашиг олсон, 2010 онд зарим банкууд валютын арилжаанаас их хэмжээний орлого олсон нь системийн активын өгөөжийг харгалзан 2.0%, 2.1%-иар өсгөхөд нөлөөлжээ.

5. ДҮГНЭЛТ

Цаашид банкуудын зүгээс зээлийн эрсдэлийн удирдлагаа бэхжүүлэх, дотоод хяналт шалгалтын тогтолцоогоо сайжруулах нь ашигт ажиллагааг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж, банкны салбарын ашигт ажиллагааг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой байгаа нь судалгааны үр дүнгээр харагдлаа.

Сүүлийн жилүүдэд хүүний бус орлого тэр дундаа валютын дахин үнэлгээ болон арилжааны орлогын ашигт ажиллагаанд эерэгээр нөлөөлөх нөлөөлөл нэмэгдсэн ч энэ нь эрсдэл өндөртэй, ашгийн найдвартай эх үүсвэр болж чаддаггүй. АНУ-ын банкны системд хийсэн Stiroh (2004)-ийн судалгаагаар банкууд хүүний бус орлогод түшиглэн ашигт ажиллагаагаа нэмэгдүүлэх боломжтой хэдий ч ийм төрлийн ялангуяа валют, үнэт цаасны орлогын эх үүсвэр нь эрсдэл өндөртэй гэдгийг судалгаагаараа харуулсан байдаг.

Цаашид банкууд ханшийн эрсдэлийн удирдлагаа бэхжүүлж, ханшийн таамаглалыг хийх болон санхүүгийн хэрэгслүүдийг ашиглан хеджинг хийх замаар хөрөнгөө оновчтой байршуулах нь ашгийн түвшинг нэмэгдүүлэх боломжтой юм.

Судалгааны үр дүнгээр банкны системийн үйл ажиллагааны зардлын зарцуулалт үр ашиг багатай гэсэн үр дүн гарсан боловч энэ нь дунд болон урт хугацааны дараа үр дүнгээ өгч болох тул нэгдсэн дүгнэлт өгөх боломжгүй юм.

Бусад хүчин зүйлс тогтмол нөхцөлд эдийн засгийн эрчимтэй өсөлтөөс шалтгаалж банкны системийн активын өгөөж 2011-2015 онуудад дунджаар 5.0% байх төлөвтэй гарсан. Гэвч эдийн засгийн хурдацтай өсөлтийн гол хүчин зүйл болж байгаа гадны хөрөнгийн дотогшлох урсгал нь эдийн засгийн хэт халалтыг үүсгэх, ханш чангаруулах, өрсөлдөх чадварыг бууруулах, хямралд өртөх эмзэх байдлыг нэмэгдүүлдэг зэрэг сөрөг нөлөө үзүүлдэг тул банкны салбарын ашигт сөргөөр нөлөөлөх магадлалтай юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Abbasoglu O F, Aysan A F, Gunes A (2007). Concentration, competition, efficiency, and profitability of the Turkish banking sector in the Post-Crisis Period. *Banks and Bank Systems*, 2 (3): 106–115

Akhavain J, Berger A N, Humphrey D B (1997). The effects of megamergers on efficiency and prices: Evidence from a bank profit function. *Review of Industrial Organization*, 12 (1): 95–139

Athanasoglou P P, Brissimis S N, Delis M D (2007). Bank specific, industry specific and macroeconomic determinants of bank profitability. Forthcoming in *Journal of International Financial Markets, Institutions and Money*

Ben Naceur S, Goaid M (2008). The determinants of commercial bank interest margin and profitability: Evidence from Tunisia. *Frontiers in Finance and Economics*, 5 (1): 106–130

Berger A N (1995). The relationship between capital and earnings in banking. *Journal of Money, Credit and Banking*, 27: 432–456

- Berger A N, DeYoung R (1997). Problem loans and cost efficiency in commercial banks. *Journal of Banking and Finance*, 21 (6): 849–870
- Chantapong S (2005). Comparative study of domestic and foreign bank performance in Thailand: The regression analysis. *Economic Change and Restructuring*, 38 (1): 63–83
- Dermiguc Kunt A, Huizinga H (1999). Determinants of commercial bank interest margins and profitability: Some international evidence. *World Bank Economic Review*, 13: 379–408
- Dermiguc K A, Huizinga H (2001). Financial structure and bank profitability, in *Financial Structure and Economic Growth: A Cross Country Comparison of Banks, Markets and Development*, Dermiguc Kunt A, Levine R (eds.). Cambridge, MA: MIT Press
- Eichengreen B, Gibson H D (2001). Greek banking at the dawn of the New Millennium, CEPR Discussion Paper
- Guru B K, Staunton J, Balashanmugam B (2002). Determinants of commercial bank profitability in Malaysia. Working Paper, Multimedia University.
- Kosmidou K (2008). The determinants of banks' profits in Greece during the period of EU financial integration. *Managerial Finance*, 34 (3): 146–159
- Kosmidou K, Pasiouras F, Tsaklanganos A (2007). Domestic and multinational determinants of foreign bank profits: The case of Greek banks operating abroad. *Journal of Multinational Financial Management*, 17: 1–15
- Kosmidou K, Zopounidis C (2008). Measurement of bank performance in Greece, South Eastern Europe *Journal of Economics*, (1): 79–95
- Mamatzakis E C, Remoundos P C (2003). Determinants of Greek commercial banks profitability, 1989–2000. *Spoudai*, 53 (1): 84–94
- Molyneux P, Thornton J (1992). Determinants of European bank profitability: A note. *Journal of Banking and Finance*, 16: 1173–1178
- Pasiouras F, Kosmidou K (2007). Factors influencing the profitability of domestic and foreign commercial banks in the European Union. *Research in International Business and Finance*, 21: 222–237
- Staikouras C, Wood G (2003). The determinants of bank profitability in Europe. Paper presented at the European Applied Business Research Conference, Venice, 9–13 June

ХАВСРАЛТ

Хавсралт 1. Активын өгөөжийн үнэлгээ /2004 оноос 2010 оны эцэс, жилээр/

| Хувьсагчид | Активын өгөөж | | | | | | | |
|-------------------------|---------------|-----------|-----------|-----------|-----------|-----------|-----------|-----------|
| | (1) | | (2) | | (3) | | (4) | |
| | FE | RE | FE | RE | FE | RE | FE | RE |
| Тогтмол | 0.31 * | 0.24 *** | 0.01 | 0.01 | -0.03 | -0.02 | -0.35 | -0.05 |
| | (1.66) | (2.85) | (0.44) | (0.94) | (-1.30) | (-1.29) | (-0.24) | (-0.03) |
| Микро хувьсагчид | | | | | | | | |
| LN(TA) | -0.02 * | -0.01 ** | - | - | - | - | - | - |
| | (-1.50) | (-2.46) | | | | | | |
| LIQ/TA | 0.25 * | 0.09 | 0.27 ** | 0.16 * | 0.28 ** | 0.16 | 0.29 ** | 0.16 * |
| | (1.95) | (0.79) | (2.12) | (1.48) | (2.27) | (1.56) | (2.23) | (1.48) |
| LLP/TL | -0.29 *** | -0.27 *** | -0.29 *** | -0.30 *** | -0.25 *** | -0.28 *** | -0.25 *** | -0.28 *** |
| | (-6.47) | (-7.29) | (-6.45) | (-8.31) | (-5.74) | (-7.67) | (-5.44) | (-7.40) |
| OVC/TA | -0.39 *** | -0.36 *** | -0.36 *** | -0.36 *** | -0.31 *** | -0.32 *** | -0.32 *** | -0.31 *** |
| | (-4.71) | (-4.35) | (-4.49) | (-4.72) | (-3.88) | (-4.20) | (-2.98) | (-3.06) |
| NIИ/TA | 0.21 ** | 0.24 *** | 0.20 ** | 0.25 *** | 0.23 *** | 0.26 *** | 0.24 ** | 0.25 *** |
| | (2.48) | (3.22) | (2.38) | (3.60) | (2.84) | (3.88) | (2.27) | (2.94) |
| EQASS | - | - | 0.09 | 0.11 *** | 0.08 | 0.10 *** | 0.08 | 0.10 *** |
| | | | (1.36) | (4.09) | (1.27) | (3.59) | (1.22) | (3.49) |
| Макро хувьсагчид | | | | | | | | |
| RGDP_GROWTH | - | - | - | - | 0.46 *** | 0.43 *** | 0.41 | 0.49 |
| | | | | | (2.79) | (2.80) | (0.96) | (1.17) |
| LN(RGDP) | - | - | - | - | - | - | 0.02 | 0.00 |
| | | | | | | | (0.22) | (0.00) |
| INFL | - | - | - | - | - | - | 0.0 | 0.0 |
| | | | | | | | (0.10) | (-0.09) |
| CR3 | - | - | - | - | - | - | -0.06 | 0.04 |
| | | | | | | | (-0.21) | (0.15) |
| HNI | - | - | - | - | - | - | - | - |
| DUM(2009-2010) | - | - | - | - | - | - | -0.06 | 0.04 |
| | | | | | | | (-0.21) | (0.15) |
| R ² | 50% | 57% | 50% | 57% | 55% | 57% | 55% | 57% |
| Num. Obs. | 98 | 98 | 98 | 98 | 96 | 96 | 96 | 96 |
| F test | 15.8 | | 15.7 | | 15.3 | | 9.8 | |
| Hausman statistic | 4.11 | | 0.42 | | 3.45 | | 4.88 | |
| P value | 0.53 | | 0.98 | | 0.75 | | 0.84 | |

*, **, *** харгалзан 10%, 5% болон 1%-ийн итгэх түвшинг илтгэнэ. Хаалтан дотор t-статистикийн утга.

Хавсралт 1. Активын өгөөжийн үнэлгээ /2004 оноос 2010 оны эцэс, жилээр/

| Хувьсагчид | Активын өгөөж | | | | | | | |
|-------------------------|----------------------|----------------------|----------------------|----------------------|-----|----|-----|----|
| | (5) | | (6) | | (7) | | (7) | |
| | FE | RE | FE | RE | FE | RE | FE | RE |
| Тогтмол | -0.16 (-0.14) | 0.26 (0.24) | -0.04 (-0.41) | -0.04 (-0.46) | | | | |
| Микро хувьсагчид | | | | | | | | |
| LN(TA) | - | - | - | - | - | - | - | - |
| LIQ/TA | 0.29 ** (2.25) | 0.16 (1.53) | 0.29 ** (2.25) | 0.15 (1.48) | | | | |
| LLP/TL | -0.25 *** (-5.44) | -0.27 *** (-7.36) | -0.25 *** (-5.38) | -0.28 *** (-7.35) | | | | |
| OVC/TA | -0.32 *** (-3.2) | -0.32 *** (-3.36) | -0.32 *** (-2.94) | -0.31 *** (-2.97) | | | | |
| NII/TA | 0.24 ** (2.51) | 0.26 *** (3.34) | 0.24 ** (2.27) | 0.25 *** (2.91) | | | | |
| EQASS | 0.08 (1.20) | 0.1 *** (3.53) | 0.08 (1.21) | 0.10 *** (3.49) | | | | |
| Макро хувьсагчид | | | | | | | | |
| RGDP_GR | 0.05 (1.31) | 0.03 (1.10) | 0.54 (1.03) | 0.50 (1.00) | | | | |
| LN(RGDP) | 0.01 (0.11) | -0.02 (-0.26) | - | - | | | | |
| INFL | -0.03 (0.15) | 0 (-0.02) | -0.02 (-0.10) | -0.02 (-0.10) | | | | |
| CR3 | - | - | - | - | | | | |
| HNI | - | - | 0.02 (0.04) | 0.14 (0.22) | | | | |
| DUM(2009) | 0.01 (0.34) | 0 (-0.01) | 0.01 (0.33) | 0 (0.09) | | | | |
| R ² | 56% | 57% | 56% | 57% | | | | |
| Num. Obs. | 96 | 96 | 96 | 96 | | | | |
| F test | 9.8 | | 9.9 | | | | | |
| Hausman statis | 4.66 | | 5.05 | | | | | |
| P value | 0.86 | | 0.83 | | | | | |

*, **, *** харгалзан 10%, 5% болон 1%-ийн итгэх түвшинг илтгэнэ. Хаалтан дотор t-статистикийн утга